

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 3-р сарын 21-ний байдлаар


2018 оны 3-р сарын 21-ний байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 8.9 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 5.5 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 21-ний байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 19.1 хувь, үхрийн ястай махны үнэ 13.6 хувь, үхрийн цул махны үнэ 13.6 хувь, адууны ястай махны үнэ 1.0 хувь, ямааны махны үнэ 24.5 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 13.5 хувь, үхрийн ястай махны үнэ 7.0 хувь, үхрийн цул махны үнэ 4.7 хувь, ямааны ястай махны үнэ 16.0 хувиар өссөн бол адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 3-р сарын 21-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7080 төгрөг, үхрийн /ястай/ мах 8075 төгрөг, үхрийн цул мах 9615 төгрөг, адууны /ястай/ мах 5575 төгрөг, ямааны /ястай/ мах 5065 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2018 оны 3-р сарын 21-ний байдлаар савласан дээд гурилын үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногтой харьцуулахад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 21-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 21-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 16.3 хувь, луувангийн үнэ 12.0 хувь, байцааны үнэ 8.3 хувь, хүрэн манжингийн үнэ 4.9 хувь, сонгины үнэ 4.6 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ 11.1 хувь, луувангийн үнэ 12.9 хувь, байцааны үнэ 9.0 хувь, хүрэн манжингийн үнэ 4.9 хувь, сонгины үнэ 4.6 хувиар өссөн байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 3-р сарын 21-ний байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад задгай сүүний үнэ 1.0 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 8.7 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 7.0 хувиар өссөн байна. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 4.6 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 1.4 хувиар өссөн байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос 1.0 хувиар өссөн бол цөцгийн тосны үнэ өмнөх сараас 2.2 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.2 хувиар өссөн байна.